



ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
[И-мэйл](#)

СТА-ын ахлах аудитор
Ц.Базарсад
Утас: 70272287
И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	8

Эрүүл мэндийн төвийн 2013 оны Санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Эрүүл мэндийн төвийн оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба цэцэрлэгийн төсвийн шууд захирагч энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Цээл сумын эрүүл мэндийн төв тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Төрийн сангийн хяналтгүйгээс зардлыг бүлэг хооронд зохицуулалт хийх журмыг зөрчин гүйлгээ хийдэг байдал хэвийн үзэгдэл болсон байна.
- Нормын хувцас авах зардлаас 2013 оны 6 сарын 24-нд Таван тэс дэлгүүрээс 41.0 мянган төгрөгөөр саван вок авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. 3 сарын 6-нд хөтөлбөр төслийн зардлаас лабораторын оношлуур, урвалж бодис худалдан авах зорилгоор 100.0 мянган төгрөгийг няраваар дамжуулан гаргаж зарцуулсан боловч холбогдох байгууллагын бэлэн мөнгө хүлээж авсан НХМаягт МХ-1 болон бусад холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байсан ба нягтлан бодогчийн тайлбараар сумын аварга шалгаруулах спортын тэмцээнд хандив болгож Цээл сумын ЗДТГ-т

хандив болгон өгч зориулалт бусаар зарцуулсан байна.

- НЭМАжилтан Амгаланбаяр нь Төв аймгийн ЭМГ-т 1 хоногийн ажилаар томилогдон ажиллахдаа томилолтын хуудсанд ажилласан байгууллага нь нэг хоногийн хугацааг бичсэн боловч Амгаланбаяр нь өөрөө томилолтын хугацааг сунган гарын үсэг зурж томилосон газрын даргаар гарын үсэг, тамга тэмдэг дарагдаж зөвшөөрөөгүй байхад 2 хоногийн 24.0 мянган төгрөгийн томилолт илүү олгосонд акт бичигдсэн.
- Дарга Цогзолбоо, Статистикч Намжилсүрэн, НЭМАжилтан Амгаланбаяр, Жолооч Эрдэнэбаатар нар нь ЭМГазарт тайлан тушаах ажлаар 3 хоног томилогдож ажилласан ба томилолтын хуудсанд ирсэн буцсан хугацааг нэг өдрөөр бичигдсэн байхад 2 хоногоор тооцож хүн тус бүр 12.0 мянган төгрөг илүү олгож нийт 48.0 мянган төгрөгийн зөрчил, мөн дарга Цогзолбоо нь өөрөө өөртөө томилолт олгож 12.0 мянган төгрөгийн томилолт илүү авсан зөрчил илэрлээ

Дээрх нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно МУ-ын засгийн газрын 218-р тогтоолоор баталсан төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн бүх хоногоор тооцож гаргана. Гэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно гэсэн заалт, Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг байгууллагын эрх баригч батална, албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах дээд шатны байгууллага буюу албан тушаалтанд

танилцуулан, томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулж, томилолтоор ажилласан хугацааг батлуулан байр, уналгын хөлс төлсөн баримтыг бүрдүүлсний үндсэн дээр хийж дуусгана, "Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын 2-т заасан Төрийн болон үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгоно" гэсэн заадтуудыг тус тус зөрчсөн байна.

Төсвийн шууд захирагчаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс Бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа
- Ерөнхий Аудитор 2014.03.12-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч М.Дэнсмаа бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.12

Танилцуулга

1. Бид Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 2013 оны 12-р сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн шууд захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Цээл сумын Эрүүл мэндийн төв тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Цээл сумын Эрүүл мэндийн төвд тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Эрүүл мэндийн төвийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Цээл сумын ЭМТөв нь МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заалтыг хэрэгжүүлэн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан талаар шалгахад дотоод хяналт шалгалтын ажил зохион байгуулаагүй байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдлыг хянах

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар Цээл сумын ЭМТ нь зөрчилгүй санал дүгнэлт авч удирдлагын захидлаар аудитын явцад илрүүлсэн, байж болзошгүй хяналтын сул тал, хяналтыг цаашид сайжруулах зорилгоор удирдлагын захидлаар хэрэгжүүлэн ажиллах 3 зүйл бүхий зөвлөмж өгч зөвлөмжөөр өгсөн ажлыг хэрэгжүүлэн, зохион байгуулсан талаар 2013 оны 06 сарын 25-ний дотор аймгийн Аудитын газарт ирүүлэх ёстой байсан боловч одоог болтол хэрэгжүүлэн ажиллаагүй, хариуг мэдэгдээгүй байна.

2. Орлогын талаар

ЭМТөвийн Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 197599.4 мянган төгрөг, Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 193.5 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 6542.6 мянган төгрөг нийт 204335.5 мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнагдсан. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал санхүүжилт 197599.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 193.5 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 6542.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 21070.7 мянган төгрөг Бүгд 225406.2 мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнагдсан байна. Өөрийн орлого төлөвлөгөө 362.8 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 193.5 мянган төгрөг буюу 53.3 хувийг биелүүлж, 169.3 мянган төгрөгөөр буюу 46.7 хувиар тасалдуулсан байна.

Мөнгөн хөрөнгө, кассын орлого зарлагын ордерыг зөв дугаарлаагүй нь СЭЗС, ҮСГ-ын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан гатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 1-7-д Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана гэснийг мөрдөгдөхгүй байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

Санхүүгийн үйл ажиллагаанд Acolious программыг бүрэн өдөр тутам ашигладаг. Цалинг цалингийн PERWOLL тусгай программ байхгүй санхүүгийн программын цалингийн программаар боддог. Нярав программ ашигладаггүй гараар хийснийг нягтлан бодогч программд шивж оруулдаг.

Нормын хувцас авах зардлаас 6 сарын 24-нд Таван тэс дэлгүүрээс 41.0 мянган төгрөгөөр саван вок авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. 3 сарын 6-нд хөтөлбөр төслийн зардлаас лабораторын оношлуур, урвалж бодис худалдан авах зорилгоор 100.0 мянган төгрөгийг няраваар дамжуулан гаргаж зарцуулсан боловч холбогдох байгууллагын бэлэн мөнгө хүлээж авсан НХМаягт МХ-1 болон бусад холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байсан ба нягтлан бодогчийн тайлбараар сумын аварга шалгаруулах спортын тэмцээнд хандив болгож Цээл сумын ЗДТГ-т хандив болгон өгч зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн тул акт бичигдэв.

Төсөл хөтөлбөр арга хэмжээний зардлаас авто машины доторлогоонд зориулж 550.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Зарим нэг гүйлгээний төлбөрийн хуудсан дээр төрийн сангийн төлөөлөгчийн гарын үсэг тэмдэг огт байхгүй, зарим гүйлгээний гарын үсэг зурагдсан боловч тэмдэг дарагдаагүй байна. төлбөрийн хүсэлтийг бичигдсэн он сараас нь хойш 5 хоногийн дараа хийгдсэн ба зарим гүйлгээ хийсэн өдөр нь амралтын өдөр таарч байна.

2013 оны 3 сарын 1-нд бие бялдрын чийрэгжүүлэлтийн хөтөлбөрийн дагуу хийсэн тэмцээнд олгосон 120.0 мянган төгрөгнөөс ХХОАТ суутгаагүй зөрчил илэрч 12.0 мянган төгрөгийн ХАОАТ төлүүлэхээр акт бичив

2013 оны 01 сарын 24-нд иргэн Ш.Пүрэвсүрэнд урьд оны махны өр болох 222.6 мянган төгрөгийн шилжүүлсэн гүйлгээ нэхэмжлэх байхгүй, иргэн Жаргалсайханы дансруу шилжүүлсэн 944.0 мянган төгрөгийн гүйлгээ нэмэмжлэх байхгүй, иргэн Ганбаатараас худалдан авсан нүүрсэнд шилжүүлсэн 287.9 мянган төгрөгийн нэхэмжлэхгүй гүйлгээ хийсэн.

НЭМАжилтан Амгаланбаяр нь Төв аймгийн ЭМГ-т 1 хоногийн ажилаар томилогдон ажиллахдаа томилолтын хуудсанд ажилласан байгууллага нь нэг хоногийн хугацааг бичсэн боловч Амгаланбаяр нь өөрөө томилолтын хугацааг сунган гарын үсэг зурж томилосон газрын даргаар гарын үсэг, тамга тэмдэг дарагдаж зөвшөөрөөгүй байхад 2 хоногийн 24.0 мянган төгрөгийн томилолт илүү олгосонд акт бичигдсэн.

Дарга Цогзолбоо, Статистикч Намжилсүрэн, НЭМАжилтан Амгаланбаяр, Жолооч Эрдэнэбаатар нар нь ЭМГазарт тайлан тушаах ажлаар 3 хоног томилогдож ажилласан ба томилолтын хуудсанд ирсэн буцсан хугацааг нэг өдрөөр бичигдсэн байхад 2 хоногоор тооцож хүн тус бүр 12.0 мянган төгрөг илүү олгож нийт 48.0 мянган төгрөгийн зөрчил, мөн дарга Цогзолбоо нь өөрөө өөртөө томилолт олгож 12.0 мянган төгрөгийн томилолт илүү авсан зөрчил илэрлээ. Энэ нь МУ-ын засгийн газрын 218-р тогтоолоор баталсан төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн бүх хоногоор тооцож гаргана. Гэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно гэсэн заалт, Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг байгууллагын эрх баригч батална, албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах дээд шатны байгууллага буюу албан тушаалтанд танилцуулан, томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулж, томилолтоор ажилласан хугацааг батлуулан байр, уналгын хөлс төлсөн баримтыг бүрдүүлсний үндсэн дээр хийж дуусгана гэсэн заадтуудыг тус тус зөрчсөн байна.

Вакцинатор сувилагч Л.Ууган, Бага эмч Анхмандах ЭМГ-р томилолтын хуудсаа ирсэн хоногоо 18 буцсан хоногоо 19-өөр бөглүүлж ирсэн байхад 2 хоногийн томилолтын зардал нийт 24.0 мянган төгрөг олгож, 12.0 мянган төгрөгөөр илүү зөрчил илэрлээ. Энэ нь “Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын 2-т заасан Төрийн болон үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгоно” гэсэн заалтыг зөрчиж байна.

Нүүрсний сүүлийн хагас жилийн нэхэмжлэхийг тулган шалгахад Э.Ганбаатараас 2012.11.27-ны 7,050*150,0-1057500 нэхэмжилсэнийг 2013.09.18-ны 15 тоотгоор 1232.0 мянган төгрөг нүүрсний үлдэгдэл гэж илүү 174.5 мянган төгрөг шилжүүлсэн.

Мөн 2013.11.19 750.0 = 5*150.0 Буянбат хадгаламж банк 3120004800 тоот дансанд 2013.11.21 Э.Ганбаатар хадгаламж банк 31200003841 тоот дансанд 5.7*170,0=969.0 2013.12.23-ны нэхэмжлэхээр 510514 Хаан банк Жаргалсайхан 5065138290 тоот дансанд, 2013.12.25-нд он саргүй нэхэмжлэхээр мөн дээрх Жаргалсайхан 219652 төгрөг цахилгааны зардлаас шилжүүлсэн байна.

4. Бараа материалын талаар

Эд харицагч нь Бараа материалын тайлан гаргахдаа: Нүүрсний тайлан гаргахдаа жилдээ ганцхан удаа жилийн эцэст нэг тайлан гаргасан. Нийт 67.540 тонн нүүрс орлого авч сард авсан хэмжээгээр зарлагаа ганцхан мөсөн шаардах бичиж гаргасан. 2013.11.10-ны 31 тоот тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилж, 2013.11.20-ны дотор тайланг гаргаж өгөхийг даалгасан байна. Тооллогын комисс хөрөнгө, бараа материалыг тоолсон боловч нэгтгэл хийгээгүй, тооллогын бүртгэл данс тус бүрээр дүгнэсэн дүн байхгүй, хөрөнгийн үнийн дүн алдаатай, тооцоо бодсон акт байхгүй, складайн бүртгэлийг зөвхөн хүнсний материалд хөтөлсөн байна.

Бараа материалын тайлангаар шатах тослох материалд 5676.2 мянган төгрөгийн орлого авч зарлага гарган үлдэгдэл 1216.5 мянган төгрөгийг нүүрсний үлдэгдэл бүтэн жилд хөдлөөгүй үлдэгдлээр хэвээр нь үлдээсэн, бараа материалын тооллогын бүртгэлд тоологдоогүй тул дутагдсан гэж үзэж 1216.5 мянган төгрөгийн акт бичигдсэн.

ЭМТөв нь хөрөнгийн тооллого огт хийгдээгүй байна. 2013 онд жилд 3 удаа байгууллагын нярав солигдсон боловч тооллого хийж хүлээлцээгүйгээс бараа материалын тайланд нүүрсний 1216.5 мянган төгрөгийн үлдэгдлийг огт хүлээлцэж байгаагүйгээс 2013 онд огт хөдлөөгүй, жилийн эцсийн тооллогын бүртгэлд тоологдоогүй учраас дутагдал гэж үзэж хариуцсан няравуудаар төлүүлэхээр акт бичигдсэн. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2.1 “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ” гэсэн заалтын дагуу байгууллагын даргын тушаалаар комисс томилогдож тооллогыг хийж, тооцоо бодсон актыг үйлдсэн байна”, 11.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед заавал тооллого хийнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар тээвэр шатахуунд 7314.2 мянган төгрөг шилжүүлж бараа материалын тайланд мянган төгрөгийн орлого авч, Үр дүнгийн тайлангаар 4314.2 мянган төгрөгийн зарлага гаргаж эцсийн үлдэгдэл мянган төгрөг байна.

Шатахууны няравын тайлан гаргаагүй, тооцоо бодсон акт байхгүй, жолоочийн тооцоог шатахууны годгор бичгийг хавсарган шатахуун зарцуулалтын норм нормативыг мөрдөөгүй зөвхөн олгосон шатахуун тохируулан км бичиж тооцоо бодоогүй, спидометрийн заалтаар тооцоо хийдэггүй, шатахуун олгохдоо нягтлан бодогч хяналт хийдэггүй зөвхөн эрхлэгчийн цохолтоор олгож, нягтлан бодогч хяналт хийж шатахуун зарцуулалтын илүү дутууг огт тооцоогүй байна. Шатахууны тооцоо бодолт огт хийгдээгүй байна.

Няравын тайлангийн шаардах хуудасны олгосон зөвшөөрсөн хэсгийн дүнг бөглөөгүй анхан шатны баримтын бүрдэл хангалгүй байна.

Аудитын явцад Сангийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягыг хэрхэн хөтөлж байгааг 2013 оны 01 сарын 01-ээс 09 сарын 31-р тасалбар болсон санхүүгийн баримтаас шалгахад анхан шатны баримтын бүрдэл, тайлан гаргалт тооцоо бодолт хангалтгүй байна. Эрхлэгч эмч Цогзолбоо нь баталгаатай гарын үсгээр бус санхүүгийн баримтанд өөр өөр янзаар зурж байна.

Орлого зарлагын баримтыг дугаарлаагүй нь СЭЗС, ҮСГ-ын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан гатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын 1-7-д Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана гэснийг зөрчсөн байна.

5. Үндсэн хөрөнгийн талаар

Сумын ИТХ-ын 2013.12.25-ны 56 тоотор тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 1255479.52 төгрөгийн хөрөнгө актлахаар шийдвэр гарсан байхад 1208368.65 төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Хангамжийн материалаас 2156633.01 төгрөгийн 2156633.00 төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Тайланд онд Яамны хөрөнгө оруулалтаар 19032.1 мянган төгрөгийн УАЗ-31512 автомашин, төсвийн хөрөнгөөр 585.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 950.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 98.0 мянган төгрөгийн хөрөнгө тавилга эд хогшил хандиваар авсан байна.

Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллого хийсэн гэх боловч тоолсон хөрөнгийг дансны бүртгэлтэй тулгаж илүүдсэн, дутсан хөрөнгийн тооцоог гаргаж үр дүнг нь тооцоогүй, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна.

Мөн программыг бүрэн ашиглаж үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, хүн тус бүрийн картыг программаар гаргадаггүй, тооллогын комиссын тооллогын нэгтгэлийг үндэслэн тоологдсон хөрөнгө тус бүрийг программд шивж оруулаагүй хангалтгүй ажилласан байна.

6. Авлага, өглөгийн талаар

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтэрийн данстай тулган баталгаажуулсан.

Нийгмийн даатгалын хэлтсийн авлага, өглөгийн тулган баталгаажуулалтын материалтай шимтгэлийн тооцоог тулгахад оны эхэнд 320.4 мянган төгрөгийн авлага, байгуулсан шимтгэл нь 30503.2 мянган төгрөг, төлсөн шимтгэл нь 30269.9 мянган төгрөг, 12.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

7. Цалингийн талаар

Сар бүрийн ажилчдын цагийн бүртгэл /НХМаягт ЦХ-2/ засвар ихтэй Сарын эцэст цаг бүртгэгч ажлын цагийн тооцоог хүн нэг бүрээр болон, тасаг, ээлж, хэсгийн хэмжээнд гаргаж хариуцсан нягтлан бодогчоор шалгуулж хүлээлгэн өгч ажлын цагийн тооцоог үндэслэн цалин хөлсний тооцоог хийх тул цаг бүртгэгчид тоог цэвэр нямбай, засваргүйгээр нөхөн бичсэн байх шаардлагатай. Хариуцсан нягтлан бодогч ажлын цагийн тооцоог ажлын цаг ашиглалтын бүртгэлтэй хүн нэг бүрээр тулган шалгаж хүлээн авсны эцэст, дараагийн шатны цаг ашиглалтын бүртгэлийг олгоно гэсэн Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс орж ирсэн листний мөнгийг сургалт семинарын зардлаар тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын төлбөр тооцооны журмын 4.7.2-д нэр данс зөрүүтэй орлогыг орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

8.Эргэлтийн эмийн сан

2013 оны эхний үлдэгдэл 3771.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7236.0 мянган төгрөг, мөнгөн орлого 22078.4 мянган төгрөг, мөнгөн зарлага нь бараа материал авахад 17857.8 мянган төгрөг, эмийн санчийн урамшуулалд 114.6 мянган төгрөг, гэрэл

цахилгааны зардалд 758.4 мянган төгрөг, шатахуунд 92.5 мянган төгрөг тус тус зарцуулж цэвэр мөнгөн гүйлгээний дүн 3255.0 мянган төгрөг байна.

Тайлангийн авлагын эцсийн үлдэгдэл 768.0 мянган төгрөгөөр тайлагнагдсаныг 567.4 мянган төгрөгийн буруу хийгдсэн бичилтийг залруулж эцсийн үлдэгдэл 1335.4 мянган төгрөг болж нэмэгдсэн.

Биет бус хөрөнгө 880.0 мянган төгрөгийн программыг орлогыг буруу бичиж өглөг үүсгэсэнийг залруулсан.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 7 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

6. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Санхүүгийн болон лидер -3 программыг бүрэн эзэмших
- Цалингийн программыг бүрэн ашиглах

7. Эдгээр асуудлуудыг ААГ болон Цээл сумын Эрүүл мэндийн төв авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

8. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

9. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд сургуулийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх онд өгөгдсөн дээрх зөвлөмжийн биелэлтийг цэцэрлэгийн эрхлэгч албан тоотоор ирүүлсэн ба аудитын явцад дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг дахин шалгасан болно. Дээрх зөвлөмжийн 3 ба 6 дахь зөвлөмжөөс бусад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ААГ

2014.03.06